

ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ МЭДЭЭ

Гадаад зах зээл

2023.07.28





ОНЦЛОХ МЭДЭЭ :

Хөрөнгийн зах зээл цаашид өсөх хандлагатай байна.


Өнгөрсөн 7 хоногт хөрөнгийн зах зээлд үүсч буй эерэг хүчин зүйлс

ХНС болон бусад олон улсын төв банкнууд хатуу мөнгөний бодлого баримтлахаа зогсоох дөхсөн, инфляц буурсаар байгаа ба өсөлт үргэлжилсээр. Эдгээр хүчин зүйлсийн улмаас хөрөнгийн зах зээлд дан ганц технологи гэлтгүй бусад бага үнэлгээтэй хувьцаа, эдийн засгийн мөчлөгөөс хамааралтай хувьцаанууд сүүлийн хэдэн 7 хоног өсөлт үзүүлсэн.

1.Өнгөрсөн 7 хоногт бодлогын хүү сүүлийн удаа өсөв үү?

- Шинжээчдийн таамаглаж байсанчлан ХНС бодлогын хүүг 0.25%-иар өсгөн 5.5%-д хүргэсэн. ХНС-ийн ерөнхийлөгч Жером Пауэлл “даалгаврыг амжилттай биелүүлсэн” гэж зарлахаас сэргийлж байсан. Тэрээр цаашдын мөнгөний бодлогын хурлаар ямар шийдвэрт хүрэх талаар мэдэгдэл өгөөгүй юм.
- ХНС болон хөрөнгө оруулагчид 9 сарын 20 хүртэл нэмж 2 удаагийн инфляц ба АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн мэдээтэй танилцах юм. Эдгээр мэдээнээс бодлогын хүү цаашид хэрхэх талаар илүү ойлголттой болох юм.
- Ерөнхийлөгч Пауэлл харин инфляцыг оргил цэгээсээ унасныг хүлээн зөвшөөрсөн юм. Нэрлэсэн ХҮИ 2022 оны 6 сарын дээд цэг болох 9.1%-иас 3.0% хүртэл унаад байна. Суурь инфляц хажууд нь 4.8%-тай байгаа нь өндөр хэвээр байгаа юм. Гол шалтгаан нь үйлчилгээний салбарт ажиглагдаж буй эрэлт хүчтэй байхаас гадна цалингийн өсөлт буухгүй байгаатай холбоотой. ХНС суурь инфляцыг дорвитой буухаас нааш хатуу мөнгөний бодлогыг зогсоохгүй болов уу.

2024 оны 3-р сараас бодлогын хүүгийн хүлээлт




- Гэвч, Edward Jones-ийн шинжээчдийн үзэж буйгаар өнгөрсөн 7 хоногийн бодлогын хүүгийн өсөлт эцсийн байх боломжтой гэв. ХНС сүүлийн жил хагасын хугацаанд бодлогын хүүг 5%-иас дээш хүргэсэн ба одоо түр зогсож инфляц болоод эдийн засагт хэр нөлөөлж байгааг ажиглах байх. Инфляцыг урьдчилан харуулдаг үйлдвэрлэл, үйлчилгээний ISM үнэ сүүлийн үед буурсаар байгаа ба орон сууцны худалдах үнэ, түрээсийн үнэ бүгд буурсаар байгаа.
- ХНС бодлогын хүүг өсгөхөө зогсоож магадгүй ч ирэх жилээс наана буулгахгүй л болов уу. Хэрвээ инфляцын түвшин 2%-д хүрэх юм бол ХНС ирэх жилийн эхээр бодлогын хүүг зөөлрүүлж магадгүй. Иймд, шинжээчид бодлогын хүүг 2024 оны эхэн хүртэл буухгүй гэж үзэж байна.

- ХНС-ийн хажуугаар Европ болон Японы төв банкнууд мөнгөний бодлогын мэдээгээ танилцуулсан. Европын төв банк бодлогын хүүгээ 0.25%-иар буюу 9-дөх удаагаа өсгөснөөр 3.75%-д хүргэсэн юм. Харин Японы төв банк 4 сард 2023 онд инфляцыг 1.8%-д хүрнэ гэж төсөөлж байсан бол энэ удаа 2.5% болгож өсгөв. Төв банкнууд ийнхүү бодлогын хүүг өсгөснөөр өрх болоод компаниудын зээлийн хүүг өсгөх тул инфляцыг буух гол нэг шалтгаан болж өгч байна.

АНУ-ын ДНБ мэдээгээр компаниудын ашгийн өсөлт сайн, инфляц буурсаар байгааг харуулав.

- Өнгөрсөн 7 хоногийн ДНБ мэдээнд АНУ-ын эдийн засаг II улиралд 2.4%-иар өссөн нь таамаглаж байснаас (1.8%) илүү байсан юм. Энэхүү өсөлтийн гол хөдөлгүүр нь бизнесүүдийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, түүхий эд материал элбэг болж эхэлсэнтэй холбоотой байв. Өрхийн хэрэглээ 1.6%-иар өссөн нь таамаглаж байсан 1.2%-иас илүү боловч өнгөрсөн улирлын 4.2%-иас бага байсан юм.
- ДНБ мэдээг дүгнээд үзэхэд, эдийн засаг саарч байгаа ч хямрал болох шинж одоогоор ажиглагдахгүй байна. Нэрлэсэн үнийн индексийн (инфляц) таамаглал 3%-иас 2.2% болж буурсан бол суурь үнийн индекс 4.2%-иас буурч 4.1% болсон. Хэрвээ эдийн засгийн өсөлт үргэлжлэх юм бол эдгээр инфляцын үзүүлэлтүүд буурахгүйг харуулж байна.



Хөрөнгийн зах зээл ерөнхийдөө яг зөв нөхцөл байдлыг хүлээж байна.

Сүүлийн үед хөрөнгийн зах зээл хиймэл оюун ухааны хөөрлөөр ихээхэн өссөн хэдий ч цаашдын өсөлтийн үндэс болох 3 хүчин зүйлс байна.

- ХНС болон бусад олон улсын төв банкнууд хатуу мөнгөний бодлого баримтлахаа зогсоох дөхсөн,
- Инфляц буурсаар байгаа
- Өсөлт үргэлжилсээр


- Эдгээр хүчин зүйлсийн улмаас хөрөнгийн зах зээлд дан ганц технологи гэлтгүй бусад бага үнэлгээтэй хувьцаа, эдийн засгийн мөчлөгөөс хамааралтай хувьцаанууд сүүлийн хэдэн 7 хоног өсөлт үзүүлсэн.



- Гэвч шинжээчид сүүлийн хагас жилд өмнөх шиг өсөлтийг хүлээхгүй байхыг анхааруулж байна. АНУ-ын эдийн засгийн гол хөдөлгүүр болсон өрхийн хэрэглээ зуны дараа удааширдаг. Бодлогын хүү өссөөр байгаа нь эрэлтийг бууруулж, ажлын байр шинээр нэмэгдэхэд саад учруулж магадгүй байна.
- Гэсэн хэдий ч ирэх 12-24 сарын дүр зураг өөдрөг байх хэвээрээ байна. Өмнө дурдсанчлан ХНС бодлогын хүүг 2024 онд буулгах хүлээлттэй байгаагаас гадна инфляц тэр үед ёроолдох байх. Дээрээс нь компаниудын ашиг 2023 оны уналттай байсан жилтэй харьцуулахад илүү өсөлттэй байх талаар дурджээ.

Хөрөнгийн зах зээл хүчтэй өссөний дараа хаана өөр боломжууд байна?

- S&P 500 индекс энэ жил 18% өссөний дараа хөрөнгө оруулагчид багцаа хэрхэн бүрдүүлэх дээр эргэлзээтэй байж магадгүй. Гэвч Edward Jones-ийн шинжээчид хувьцаа болон бондын зах зээлд анхаарал татахуйц боломжууд байгаа талаар дурджээ.
- Зах сүүлийн хэдэн сар хүчтэй өссөн тул замд үе үе уналтууд тохиолдохыг үгүйсгэхгүй. Хэдийгээр захыг өсөхөд нөлөөлсөн “хүчит 7” хувьцаа байгаа ч үнэлгээ хэт өсчихөөгүй хувьцаанууд бас байна. Хэрвээ ирэх жилээс бодлогын хүү болон бондын өгөөж буурч, эдийн засаг сэргэх юм бол үйлдвэрлэл, материалын салбарт өсөлт ажиглагдаж магадгүй юм.



- Edward Jones-өөс урт хугацааны хөрөнгө оруулалтын зэрэглэлийн бондыг санал болгож байна. Бодлогын хүү буурснаар бондын ханш өсдөг тул ханшийн өгөөж мөн хүртэх боломжтой юм.

САНАМЖ

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!